

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	4
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	6
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	8
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	8
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	9
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	10
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ  
БОДЛОГЫН ДЭМЖЛЭГ ТӨСЛИЙН  
ЗОХИЦУУЛАГЧ Г.НАРАНГУА  
ТАНАА

2020.02.27 № 06/629  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг төслийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

“Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг” төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн зохицуулагч Г.Нарангуа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг” төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг” төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 27-ноос 2020 оны 2 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 24-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Грант Торнтон аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

“Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг” төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Грант Торнтон аудит” ХХК-д 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 3/2020 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

“Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг” төслийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Төвлөрлийг сааруулах үйл явцыг дэс дараатай, харилцан уялдаа холбоотой, цогц байдлаар хэрэгжүүлэх, улмаар төрийн үйлчилгээг иргэдэд илүү үр дүнтэй, шуурхай,

хүртээмжтэй хүргэх, ил тод, хариуцлагатай засаглалыг хөгжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг, туслалцаа үзүүлэхэд оршино.

“Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг” төслийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төвлөрлийг сааруулах стратегийн баримт бичиг боловсруулах,
- Чиг үүргийг дахин хуваарилах аргачлалыг сонгож авсан салбарт турших,
- Чиг үүргийг дахин хуваарилах аргачлалыг бусад салбарт хэрэгжүүлэх,
- Төсвийн тэнцвэржүүлэлтийн асуудлаар ажиллах,
- Бодлогын тасралтгүй дэмжлэг үзүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд томоохон өөрчлөлт гараагүй байна.

“Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг” төслийн үйл ажиллагаа, хэрэгжилтэд Швейцарын хөгжлийн агентлаг хяналт тавьж, санхүүжүүлдэг.

Төслийн нэгдүгээр шат 2020 оны нэгдүгээр улиралд дуусаж, хоёрдугаар шат хэрэгжиж эхэлнэ.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг” төслийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг байна.

“Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг” төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар “Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг” төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 6 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлт болон хувь хэмжээг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн бөгөөд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 700,889.0 мянган төгрөгийн 1 хувиар тооцон 7,008.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг” төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 74,466.1 мянган төгрөгөөр буюу 42.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	166,319.6	95,753.8	(70,565.8)
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	3,288.6	1,115.7	(2,172.9)
Үндсэн хөрөнгө	4,137.8	2,410.4	(1,727.4)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>173,746.0</b>	<b>99,279.9</b>	<b>(74,466.1)</b>
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	173,746.0	99,279.9	(74,466.1)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>173,746.0</b>	<b>99,279.9</b>	<b>(74,466.1)</b>

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 99,279.9 мянган төгрөг болж 74,466.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны алдагдлаас шалтгаалжээ.

“Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг” төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэнд Швейцарын хөгжлийн агентлаг 100 хувь хяналт тавьж, санхүүжүүлдэг. Хөтөлбөрийн дагуу санхүүжүүлсэн орлогоос зарцуулаагүй байгаа дүнгээр мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлтэй байна.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Нэмэлт төсөв:** Швейцарын хөгжлийн агентлагын санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрөөс 620,000.0 мянган төгрөг, хүүгийн орлого 6,455.2 мянган төгрөг, нийт 626,455.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Мөн өмнөх оны санхүүжилтийн үлдэгдэл болох мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 166,319.6 мянган төгрөгтэй байсан.

Үүнээс: Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 179,866.9 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, хангамж, албан томилолтын зардалд 47,538.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 469,616.0 мянган төгрөг нийт 697,021.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 6 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 8 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 6,853.1 мянган төгрөгийн алдаа илэрснийг залруулж В30103 маягтаар баталгаажуулсан.

## 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

“Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг” төсөл Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 134 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн, 15 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Төсөв гүйцэтгэлтэй холбоотой 49 мэдээлэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой 39 мэдээлэл, бусад 61 мэдээлэл байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Нийт 2 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид “Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг” төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

### **“Зөрчилгүй” дүгнэлт**

“Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг” төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, НББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>169,608,246.07</b>	<b>96,869,505.61</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>166,319,666.07</b>	<b>95,753,845.61</b>
<b>31100</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	<b>148,250.00</b>	<b>174,540.00</b>
31130	Касс	148,250.00	174,540.00
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>166,171,416.07</b>	<b>95,579,305.61</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>166,171,416.07</b>	<b>95,579,305.61</b>
31216	Харилцах данс (Нэмэлт санхүүжилт)	166,171,416.07	95,579,305.61
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>3,288,580.00</b>	<b>1,115,660.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>3,288,580.00</b>	<b>1,115,660.00</b>
35410	Бичиг хэргийн материал	3,114,280.00	934,800.00
35420	Аж ахуйн материал	174,300.00	180,860.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,137,801.26</b>	<b>2,410,418.42</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>4,137,801.26</b>	<b>2,410,418.42</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>3,817,801.26</b>	<b>2,210,418.42</b>
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	8,785,182.00	8,785,182.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-5,455,444.00	-7,212,480.40
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	867,981.89	1,255,881.89
39208	Хуримтлагдсан элэгдэл	-379,918.63	-618,165.07
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>320,000.00</b>	<b>200,000.00</b>
39301	Програм хангамж	600,000.00	600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-280,000.00	-400,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>173,746,047.33</b>	<b>99,279,924.03</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>173,746,047.33</b>	<b>99,279,924.03</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>173,746,047.33</b>	<b>99,279,924.03</b>
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>173,746,047.33</b>	<b>99,279,924.03</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	21,877,757.34	173,746,047.33
51220	Тайлант үеийн үр дүн	151,868,289.99	-74,466,123.30
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>173,746,047.33</b>	<b>99,279,924.03</b>

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>498,972,912.18</b>	<b>626,455,217.28</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	498,972,912.18	626,455,217.28
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	497,000,000.00	620,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,972,912.18	6,455,217.28
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>347,104,622.19</b>	<b>700,921,340.58</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>347,104,622.19</b>	<b>700,921,340.58</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	347,104,622.19	700,721,340.58
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	169,946,277.73	180,741,899.74
210101	Үндсэн цалин	150,097,977.21	162,176,628.14
210104	Урамшуулал	18,648,300.52	18,565,271.60
210105	Гэрээт ажлын хөлс	1,200,000.00	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	20,353,856.98	22,446,231.95
210201	Тэтгэврийн даатгал	13,595,702.47	15,288,686.47
210202	Тэтгэмжийн даатгал	1,699,462.77	1,798,669.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,359,570.22	1,438,935.22
210204	Ажилгүйдлийн даатгал	300,195.95	322,603.25
210205	Эрүүл мэндийн даатгал	3,398,925.57	3,597,338.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,967,698.90	13,141,502.88
210401	Бичиг хэрэг	958,000.00	7,512,140.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,009,698.90	2,938,632.88
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	2,690,730.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	6,000,000.00	19,709,450.00
210702	Дотоод албан томилолт	6,000,000.00	19,709,450.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	144,790,155.76	462,501,973.17
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	144,790,155.76	455,336,373.17
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	7,000,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	165,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,046,632.82	2,180,282.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	65,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,046,632.82	2,115,282.84
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	00.00	200,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	00.00	200,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	200,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>151,868,289.99</b>	<b>-74,466,123.30</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>151,868,289.99</b>	<b>-74,466,123.30</b>

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>499,072,912.18</u></b>	<b><u>626,455,217.28</u></b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>626,455,217.28</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	626,455,217.28
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	620,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	6,455,217.28
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>346,845,869.37</u></b>	<b><u>697,021,037.74</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>346,845,869.37</b>	<b>697,021,037.74</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>346,845,869.37</b>	<b>696,821,037.74</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	169,946,277.73	179,866,899.74
210101	Үндсэн цалин	150,097,977.21	161,301,628.14
210104	Урамшуулал	18,648,300.52	18,565,271.60
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	20,353,856.98	22,446,231.95
210201	Тэтгэврийн даатгал	13,595,702.47	15,288,686.47
210202	Тэтгэмжийн даатгал	1,699,462.77	1,798,669.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,359,570.22	1,438,935.22
210204	Ажилгүйдлийн даатгал	300,195.95	322,603.25
210205	Эрүүл мэндийн даатгал	3,398,925.57	3,597,338.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,193,278.90	5,382,482.88
210401	Бичиг хэрэг	1,043,080.00	1,156,560.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,150,198.90	2,938,632.88
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	1,287,290.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	6,000,000.00	19,709,450.00
210702	Дотоод албан томилолт	6,000,000.00	19,709,450.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	146,352,455.76	469,350,973.17
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	146,352,455.76	462,185,373.17
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	7,000,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	165,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	00.00	65,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>00.00</b>	<b>200,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	00.00	200,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>152,227,042.81</u></b>	<b><u>-70,565,820.46</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	152,187,042.81	-70,565,820.46
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	14,132,623.26	166,319,666.07
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	166,319,666.07	95,753,845.61

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>21,877,757.34</b>	<b>21,877,757.34</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>21,877,757.34</b>	<b>21,877,757.34</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
<b>Тайлант үеийн үр дүн</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>151,868,289.99</b>	<b>151,868,289.99</b>
<b>2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>173,746,047.33</b>	<b>173,746,047.33</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>173,746,047.33</b>	<b>173,746,047.33</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-74,466,123.30	-74,466,123.30
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>99,279,924.03</b>	<b>99,279,924.03</b>

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>697,021,037.74</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>697,021,037.74</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>696,821,037.74</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>0.00</b>	<b>179,866,899.74</b>
210101	Үндсэн цалин	0.00	161,301,628.14
210104	Урамшуулал	0.00	18,565,271.60
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>0.00</b>	<b>22,446,231.95</b>
210201	Тэтгэврийн даатгал	0.00	15,288,686.47
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	1,798,669.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	1,438,935.22
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	322,603.25
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	3,597,338.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>0.00</b>	<b>5,382,482.00</b>
210401	Бичиг хэрэг	0.00	1,156,560.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	2,938,632.88
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	1,287,290.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>0.00</b>	<b>19,709,450.00</b>
210702	Дотоод албан томилолт	0.00	19,709,450.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>0.00</b>	<b>469,350,973.17</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	462,185,373.17
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	7,000,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	165,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>0.00</b>	<b>65,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	65,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>0.00</b>	<b>200,000.00</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	200,000.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>36</b>	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	0.00	620,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	6,455,217.28
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	166,319,666.07
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	95,753,845.61
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>4.00</b>	<b>4.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	3.00	3.00

ТЭМДЭГЛЭЛ

Dotted lines for writing.

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing.

